



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 11 өдөр

Дугаар: 11178

Арвайхээр сум

### Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1, Захиргааны өрөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрдэнэзүү музеийн “Аялал жуулчлалын гудамж” төсөл (Өвөрхангай, Хархорин сум) үргэлжлэл ажлын тендерийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ц.Идэрсайхан (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авахажиллагааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Ц.Нямдалай (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)

Ц.Оюун (Иргэний төлөөлөл) (зөвшилцсөнөөр)

Г.Гантэмэр (Оновчтой хөгжил ТББ-ын тэргүүн) (зөвшилцсөнөөр)


Нарийн бичиг:

Б.Баттөр (аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газрын Худалдан авах ажиллагаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Ц.Идэрсайхан)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж, Архив, бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичиг (Б.Баттөр)-д үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.СУМЬЯСҮРЭН

6224 11 0376